

### СПОРТОД СЭРГЭЭШ ХЭРЭГЛЭХИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (цаашид ЮНЕСКО гэх)-ын Ерөнхий Бага хурал Парис хотноо 2005 оны 10 дугаар сарын 3-21-ний өдрүүдэд хуралдуулсан 33 дугаар чуулганаараа,

боловсрол, шинжлэх ухаан, соёлоор дамжин улс хоорондын хамтын ажиллагааг дэмжин улмаар энх тайван, аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах ЮНЕСКО-гийн зорилгыг харгалзан үзэж,

олон улсын хүний эрхийн тухай одоогийн баримт бичгүүдийг ишлэл болгож,

спортоор дамжин боловсрол, эрүүл мэнд, хөгжил, энх тайвныг дэмжих тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 58/5 тоот тогтоол, ялангуяа тогтоолын 7 дахь хэсгийг харгалзан үзэж,

эрүүл мэндийг хамгаалах, ёс суртахууны болон соёл, биеийн тамирын боловсрол, улмаар олон улсын харилцан ойлголцол, энх тайвныг дэмжихэд спорт чухал үүрэг гүйцэтгэх ёстойг ухамсарлаж,

спортод сэргээш хэрэглэхийг зогсооход чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг дэмжих, зохицуулах шаардлагатайг тэмдэглэж,

тамирчид спортод сэргээшийг хэрэглэж, түүнээс үүдэн тэдний эрүүл мэнд, тэмцэлдээний шударга байх зарчимд уршиг учруулж буйд сэтгэл гүнээс зовниж, хууран мэхлэх явдлыг арилган спортын ирээдүйг анхаарч,

ЮНЕСКО-гийн биеийн тамирын боловсрол, спортын олон улсын дүрэм болон Олимпийн дүрэмд тусгагдсан ёс зүйн зарчмууд, боловсролын үнэт зүйлсийг сэргээш нь эрсдэлд хүргэж буйг ухамсарлаж,

Европын зөвлөлийн хүрээнд батлагдсан Сэргээшийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протокол нь сэргээшийн эсрэг үндэсний бодлого, засгийн газар хоорондын хамтын ажиллагааны эхлэлийг тавьж буй олон улсын нийтийн эрх зүйн баримт бичиг болохыг эргэн санаж,

ЮНЕСКО-оос 1988 онд Москвад, 1999 онд Пунта Дэл Эстэд, 2004 онд Афинд тус тус зохион байгуулсан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн сайд, ахлах ажилтнуудын хоёр, гурав, дөрөвдүгээр олон улсын бага хурлаас

Монгол Улсын Гадаад Хэргийн Яам  
Албан ёсны орчуулга мөн  
Гарын үсэг /Signature/ .....  
2007 оны 6 сарын 11 өдөр  
Улаанбаатар хот  
Ministry for Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

УИХ-ын архив  
Бүртгэлийн № 125  
ХУУЛБАР ҮНЭН  
2017 оны 06 сарын 09  
Гарын үсэг

гаргасан зөвлөмжүүдийг болон ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 2003 оны 32 дугаар хуралдаанаас батласан 32 С/9 тогтоолыг эргэн санаж,

Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг дэлхийн бага хурлын 2003 оны 3 дугаар сарын 5-ны хуралдаанаар Сэргээшийн эсрэг дэлхийн агентлагаас батлуулсан Сэргээш хэрэглэхийн эсрэг дүрэм болон Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг Копенгагены тунхаглалыг анхааралдаа авч,

шилдэг тамирчдаас залуучуудад үзүүлэх нөлөөллийг мөн анхаарч,

сэргээшийн илрүүлэлтийг сайжруулах, түүнийг хэрэглэж буй шалтгаануудыг сайтар судлах замаар хамгийн үр дүнтэй урьдчилсан сэргийлэх бодлогыг тодорхойлох зорилгоор байнгын судалгааг цаашид ч өргөжүүлэн явуулах шаардлагатайг харгалзаж,

сэргээш хэрэглэхээс урьдчилан сэргийлэх асуудлаар тамирчид, тамирчдыг дэмжих ажилтнуудад болон нийгэмд үргэлжлүүлэн боловсрол олгохын чухлыг мөн харгалзаж,

сэргээштэй тэмцэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд оролцогч улсуудын чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байгааг анхааралдаа авч,

спортод сэргээш хэрэглэхээс урьдчилан сэргийлүүлэх, түүнтэй тэмцэх, ялангуяа спортын арга хэмжээнүүдэд тохирсон удирдамжийг тэмцээний шударга байх зарчимд нийцүүлэн батлан гаргах, тэдгээрт оролцогч тамирчдын эрүүл мэндийг хамгаалах үүргийг төрийн болон спортын байгууллагууд харилцан хүлээх ёстойг анхаарч,

эдгээр зорилгыг биелүүлэхийн тулд төрийн болон спортын байгууллагууд нягт хамтран ажиллахын зэрэгцээ бүх зохих түвшинд бие даасан, ил тод байдлыг өндөр түвшинд хангах ёстойг хүлээн зөвшөөрч,

спортод сэргээш хэрэглэхийн эсрэг чиглэсэн хамтарсан арга хэмжээг цаашид илүү идэвхтэй авч байхаар шийдвэр төгс байж,

спортод сэргээш хэрэглэхгүй байх асуудал нь сэргээшийн эсрэг стандартууд болон тэдгээрийг спортод хэрэглэж буй байдал, үндэсний болон дэлхий нийтийн түвшин дэх хамтын ажиллагаанаас хамаарна гэдгийг хүлээн зөвшөөрч,

энэхүү конвенцийг 2005 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталж байна.



## I. Хамрах хүрээ

### 1 дүгээр зүйл

#### Конвенцийн зорилго

Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг урьдчилан сэргийлэх, тэмцэх, улмаар түүнийг арилгахад биеийн тамир, спортын салбар дахь ЮНЕСКО-ийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлэх нь энэ конвенцийн зорилго мөн.

### 2 дугаар зүйл

#### Нэр томъёо

Дор дурдсан нэр томъёог Сэргээшийн эсрэг дэлхийн дүрмийн агуулгын хүрээнд тодорхойлов. Харин маргаан үүсэх тохиолдолд энэхүү конвенцийн заалтууд давуу хүчинтэй.

Энэхүү конвенцийн зорилгод:

1. "Сэргээшийн хяналтын баталгаажсан лабораториуд" гэж Сэргээшийн эсрэг дэлхийн агентлагаас баталгаажуулсан төвүүдийг хэлнэ.


2. "Сэргээшийн эсрэг байгууллага" гэж сэргээшийн хяналтын үйл явцын аль нэг хэсэгтэй холбоотой журмыг санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх буюу мөрдүүлэх үүрэг хүлээсэн нэгжийг хэлнэ. Тухайн нэгжид жишээлбэл, Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, өөрсдийн арга хэмжээний үеэр сэргээшийн шинжилгээ хийдэг бусад томоохон арга хэмжээний байгууллагууд, Сэргээшийн эсрэг дэлхийн агентлаг, олон улсын холбоод болон сэргээшийн эсрэг үндэсний байгууллагуудыг хэлнэ.

3. Спортод "Сэргээшийн эсрэг журмыг зөрчих" гэж дараахь зөрчлийн аль нэгийг, эсхүл хэд хэдийг үйлдсэнийг хэлнэ:

(a) тамирчдын цусны дээжээс хориглосон бодис, эсхүл түүний хувирал буюу шинж тэмдэг илрэх;

(b) хориглосон бодис, эсхүл хориглосон арга хэрэглэх буюу хэрэглэхээр завдах;

(c) сэргээшийн эсрэг журмуудад заасны дагуу шинжилгээнд дээж өгөх тухай албан ёсны мэдэгдэл авсны дараа түүнээс татгалзах, эсхүл хүндэтгэх шалтгаангүйгээр шинжилгээ өгөөгүй буюу өгөхөд байлцаагүй;



(d) тамирчнаа хаана байгааг мэдээлж чадахгүй зэргээс шалтгаалан тэмцээний гадуурх шинжилгээнд оруулах шаардлагыг биелүүлээгүй, мөн зохих журмуудад үндэслэн мэдэгдсэн шинжилгээг өнгөрөөх;

(e) сэргээшийн хяналтын аливаа хэсэгт хөндлөнгөөс оролцох буюу хөндлөнгөөс оролцохоор завдах;

(f) хориглосон бодис, эсхүл арга барил эзэмших;

(g) аливаа хориглосон бодис, эсхүл хориглосон арга барил түгээн дэлгэрүүлэх;

(h) хориглосон бодис, эсхүл хориглосон арга барилыг аливаа тамирчинд захиргааны журмаар хэрэглүүлэх буюу захиргааны журмаар хэрэглүүлэх оролдлого хийх, эсхүл туслах, зоригжуулах, өөгшүүлэх, турхирах, нуух буюу аливаа хамтын үйлдлээр сэргээшийн эсрэг журмыг зөрчих буюу зөрчихөөр оролдох.

4. Сэргээшийн хяналтын зорилгоор “тамирчин” гэж үндэсний сэргээшийн эсрэг байгууллагаас тодорхойлсон, мөн оролцогч улсууд хүлээн зөвшөөрсөн спортын төрлөөр үндэсний болон олон улсын түвшинд оролцож байгаа бүх хүнийг хэлнэ. Боловсрол сургалтын зорилгоор тамирчин гэдэг нь спортын байгууллагын эрх мэдлийн хүрээнд спортод оролцож байгаа хүнийг хэлнэ

5. “Тамирчдыг дэмжих ажилтан” гэж спортын тэмцээнд оролцуулах буюу бэлтгэхээр ажиллах, эсхүл зохицуулж буй ахлах дасгалжуулагч, дасгалжуулагч, менежер, багийн гишүүд, албаны болон эрүүл мэндийн буюу эм зүйн ажилтныг хэлнэ.

6. “Дүрэм” гэж Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн Копенгаген хотноо болсон 2003 оны 3 дугаар сарын 5-ны хуралдаанаар батлагдсан энэхүү конвенцийн I нэмэлт хавсралтад дурдсан “Сэргээш хэрэглэхийн эсрэг дүрэм”-ийг хэлнэ.

7. “Тэмцээн” гэж нэг удаагийн уралдаан, тоглолт, наадам буюу нэг удаагийн спортын арга хэмжээг хэлнэ.

8. “Сэргээшийн хяналт” гэж шинжилгээ хийх төлөвлөлт, дээж авах, дээжийг хадгалах, лабораторид шинжилгээ хийх, үр дүнд шинжилгээний дараахь ажиллагаа, хэргийг хэлэлцэх болон давж заалдах үйл явцыг хэлнэ.

9. “Спортод сэргээш хэрэглэх” гэж сэргээшийн эсрэг журмыг зөрчихийг хэлнэ.



10. "Зохих журмын дагуу эрх олгогдсон сэргээшийн хяналтын багууд" гэж олон улсын, эсхүл үндэсний сэргээшийн эсрэг байгууллагуудын удирдлагад үүргээ гүйцэтгэж буй сэргээшийг хянах багуудыг хэлнэ.

11. "Тэмцээний шинжилгээ" гэж олон улсын холбоо, эсхүл сэргээшийн эсрэг бусад холбогдох байгууллагын журамд өөрөөр заагаагүй бол тэмцээний, тэмцээнээс гадуурх шинжилгээг хооронд нь ялгах зорилгоор тухайн тэмцээнд орж буй тамирчдаас сонгон авч буй шинжилгээ хэлнэ.

12. "Лабораториудын олон улсын стандарт" гэж энэхүү конвенцийн II нэмэлт хавсралтад дурдсан стандартыг хэлнэ.

13. "Шинжилгээ авах олон улсын стандарт" гэж энэхүү конвенцийн III нэмэлт хавсралтад дурдсан стандартыг хэлнэ.

14. "Гэнэтийн шалгалт" гэж тамирчинд урьдчилан мэдэгдэлгүйгээр шинжилгээ авах, чингэхдээ шинжилгээ авах тухай мэдэгдсэнээс хойш шинжилгээ өгтөл тамирчныг хяналтад байлгахыг хэлнэ.

15. "Олимпийн хөдөлгөөн" гэж Олимпийн дүрмийг удирдлага болгосон, Олон улсын олимпийн хорооны эрх мэдлийг хүлээн зөвшөөрсөн хэнийг ч болов, тухайлбал, Олимпийн тоглолтын хөтөлбөрт ордог спортын төрлийн олон улсын холбоод, Үндэсний олимпийн хороод, Олимпийн тоглолтыг зохион байгуулах хороод, тамирчид, спортын шүүгчид, нийгэмлэг болон багуудаас гадна Олон улсын олимпийн хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн бүх байгууллагыг хэлнэ.


16. "Тэмцээнээс гадуурх" сэргээшийн хяналт гэж тэмцээний бус үеэр авч буй аливаа хяналтыг хэлнэ.

17. "Хориглосон жагсаалт" гэж энэхүү конвенцийн I хавсралтад дурдсан стандартын хориглосон бодис болон хориглосон арга барилыг хэлнэ.

18. "Хориглосон арга барил" гэж энэхүү конвенцийн I хавсралтад дурдсан аливаа хориглосон арга барилыг хэлнэ.

19. "Хориглосон бодис" гэж энэхүү конвенцийн I хавсралтад дурдсан аливаа хориглосон бодисыг хэлнэ.

20. "Спортын байгууллага" гэж нэг болон хэд хэдэн спортын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй аливаа байгууллагыг хэлнэ.



21. “Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох стандарт” гэж энэхүү конвенцийн II хавсралтад дурдсан стандартыг хэлнэ.

22. “Шинжилгээ” гэж шинжилгээ авах төлөвлөлт, дээж авах, дээжийг хадгалах, дээжийг лабораторид тээвэрлэн хүргэх зэрэг сэргээшийн шинжилгээний үйл явцыг хэлнэ.

23. “Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох” гэж Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох стандартад нийцүүлэн олгосон хөнгөлөлтийг хэлнэ.

24. “Хэрэглээ” гэж ашиглах, залгих, тарих буюу хэрэглэх замаар аливаа хориглосон бодис, хориотой арга барилын аливаа хэлбэрийг сонгохыг хэлнэ.

25. “Дэлхийн сэргээшийн эсрэг агентлаг” (ДСЭА) гэж 1999 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Швейцарийн хууль тогтоомжоор байгуулагдсан дээрх нэртэй санг хэлнэ.

### 3 дугаар зүйл

#### Конвенцийн зорилгод хүрэх арга замууд

Конвенцийн зорилгод хүрэхийн тулд оролцогч улсууд дараахь үүргийг хүлээнэ:

(a) дүрмийн үндсэн зарчмуудад нийцсэн зохистой арга хэмжээг үндэсний болон олон улсын хэмжээнд батлах;

(b) тамирчдыг болон спорт дахь ёс зүйг хамгаалах, судалгааны үр дүнг солилцох зорилгоор олон улсын хамтын ажиллагааны бүх хэлбэрийг хөхиүлэн дэмжих;

(c) Оролцогч улсууд болон спортод сэргээш хэрэглэхийн эсрэг тэмцэлд тэргүүлэх үүрэгтэй байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, түүний дотор Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд туслах.

### 4 дүгээр зүйл

#### Конвенц Дүрэмтэй уялдах нь

1. Оролцогч улсууд нь спортод сэргээш хэрэглэхийн эсрэг тэмцлийн хэрэгжилтийг үндэсний болон олон улсын түвшинд зохицуулж байх зорилгоор энэхүү конвенцийн 5 дугаар зүйлд тусгагдсан арга хэмжээнд



үндэслэн Дүрмийн үндсэн зарчмуудыг удирдлага болгох үүрэг хүлээнэ. Оролцогч улсууд Дүрэмд нийцүүлэн нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд энэхүү конвенц ямар ч байдлаар нөлөөлөхгүй.

2. Дүрэм болон түүний II, III нэмэлт хавсралтын сүүлчийн хувилбар нь мэдээлэл өгөх зорилготой бөгөөд эдгээр нь энэхүү конвенцийн салшгүй хэсэг болохгүй. Нэмэлт хавсралтууд нь оролцогч улсуудад олон улсын эрх зүйн заавал биелүүлэх үүрэг оногдуулахгүй.

3. Харин хавсралтууд нь энэхүү конвенцийн салшгүй хэсэг мөн.

#### 5 дугаар зүйл

### Конвенцийн зорилгод хүрэх арга хэмжээнүүд

Энэхүү конвенцид заасан үүргийг биелүүлэхдээ оролцогч улс бүр холбогдох арга хэмжээ авах үүрэг хүлээнэ. Эдгээр арга хэмжээнд хууль тогтоох, зохицуулах болон бодлого хэрэгжүүлэх буюу захиргааны үйл ажиллагаа багтаж болно.

#### 6 дугаар зүйл

### Олон улсын бусад бичиг баримттай уялдах нь


Энэхүү конвенц нь оролцогч улсуудын өмнө нь байгуулсан бусад хэлэлцээрээр хүлээсэн болон энэхүү конвенцийн зорилго, зорилттой нийцэж буй эрх, үүргийг өөрчлөхгүй. Энэ нь оролцогч бусад улсын энэхүү конвенцоор хүлээсэн эрхээ эдлэх, эсхүл үүргээ биелүүлэх явдалд нөлөөлөхгүй.

## II. Үндэсний түвшинд сэргээшийн эсрэг үйл ажиллагаа

#### 7 дугаар зүйл

### Дотоодын зохицуулалт

Оролцогч улсууд нь дотоодын зохицуулалтыг уялдуулах замаар энэхүү конвенцийг биелүүлэх үүрэгтэй. Оролцогч улсууд нь энэхүү конвенцийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ сэргээшийн эсрэг байгууллагууд болон спортын газар, байгууллагуудтай хамтарч ажиллаж болно.



## 8 дугаар зүйл

### Хориглосон бодис, арга барилыг олох боломж болон спортод хэрэглэхийг хязгаарлах

1. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгохоос бусад тохиолдолд, шаардлагатай гэж үзвэл спортод сэргээш хэрэглэхээс тамирчныг сэргийлэх, хориглосон бодис болон арга барилыг олох боломжийг хязгаарлах арга хэмжээг оролцогч улсууд авна. Үүнд хориглосон бодис болон арга барилыг тамирчинд түгээхтэй тэмцэх арга хэмжээ, түүнчлэн тэдгээрийг үйлдвэрлэх, тээвэрлэх, импортлох, түгээх болон худалдаалах явдлыг хянах арга хэмжээ орно.
2. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох, эсхүл шаардлагатай гэж үзэхээс бусад тохиолдолд, тамирчинд хориглосон бодис болон арга барилыг спортод хэрэглэх, эзэмшихээс урьдчилан сэргийлэх, хязгаарлах арга хэмжээг оролцогч улсууд авах бөгөөд өөрийн хэргийн харьяалалд багтах холбогдох хуулийн этгээдүүд тийм арга хэмжээ авахаар бол тэдгээрийг хөхиүлэн дэмжинэ.
3. Спортод хориглосон, эсхүл хяналт тогтоосон бодис, эсхүл арга барилыг хууль ёсны дагуу зөвшөөрөхөд энэхүү конвенцийн дагуу бусад тохиолдолд авах арга хэмжээ нь саад болохгүй.

## 9 дүгээр зүйл


### Тамирчдыг дэмжих ажилтны эсрэг авах арга хэмжээ

Оролцогч улсууд сэргээшийн эсрэг журмыг зөрчих буюу спортод сэргээш хэрэглэхтэй холбогдсон зөрчил үйлдсэн тамирчныг дэмжих ажилтны хувьд арга хэмжээ авах, түүний дотор шийтгэл буюу торгууль ногдуулах талаар журам батлуулах арга хэмжээг спортын байгууллагууд болон сэргээшийн эсрэг байгууллагуудаар авахуулах буюу хөхиүлэн дэмжинэ.

## 10 дугаар зүйл

### Нэмэгдэл тэжээл

Тэжээлийн нэмэгдэл үйлдвэрлэгч, зуучлагчдад зарж борлуулж буй бүтээгдэхүүнийхээ бүтэц, түүний дотор химийн найрлага, чанарын баталгаа зэргийг мэдээлэх зөв хэвшил тогтоохыг оролцогч улсууд шаардлагатай тохиолдолд хөхиүлэн дэмжинэ.





11 дүгээр зүйл

Санхүүгийн арга хэмжээ

Оролцогч улсууд зохих үед:

(a) үндэсний хэмжээнд сэргээшийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг улсын төсөвтөө суулгах, спортын болон спортыг дэмжигч бүх байгууллага, сэргээшийн эсрэг байгууллагуудыг дэмжих, чингэхдээ шууд татаас буюу тусламжаар, эсхүл тэдгээр байгууллагад хуваарилах нийт татаас буюу тусламжийн хэмжээг тооцохдоо сэргээшийн хяналтад гарах зардлыг оруулж байх;

(b) сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөнд сэжиглэгдэж буй тамирчин, тамирчныг дэмжих ажилтанд зориулсан спорттой холбоотой санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тэдний сэжигтэн байх хугацааны турш зогсоох;

(c) Дүрэм буюу Дүрэмд нийцүүлэн гаргасан сэргээшийн эсрэг журмыг зөрчсөн аливаа спортын байгууллагууд, эсхүл сэргээшийн эсрэг байгууллагуудад үзүүлж буй санхүүгийн буюу спорттой холбоотой санхүүгийн тусламжийг хэсэгчлэн, эсхүл бүхлээр нь зогсоох.

12 дугаар зүйл


Сэргээшийн хяналтыг хөнгөвчлөх арга хэмжээ

Оролцогч улсууд зохих үед:

(a) спортын байгууллагууд болон сэргээшийн эсрэг байгууллагууд өөрсдийн шүүхийн харьяаллын хүрээнд, Дүрэмд нийцсэн аргаар гэнэтийн шалгалт, тэмцээнээс гадуурх болон тэмцээний үеийн шинжилгээ авах зэрэг сэргээшийн хяналтын хэрэгжүүлэлтийн ажил хийхийг хөхиүлэн дэмжих болон хөнгөвчлөх;

(b) спортын байгууллагууд болон сэргээшийн эсрэг байгууллагууд, өөрсдийн гишүүдийг бусад улсын зохих журмын дагуу эрх олгогдсон сэргээшийн хяналтын багуудаар шалгуулахыг зөвшөөрөх талаар хэлэлцээр байгуулахыг хөхиүлэн дэмжих болон хөнгөвчлөх;

(c) өөрсдийн хэргийн харьяаллын хүрээнд спортын байгууллагууд болон сэргээшийн эсрэг байгууллагууд сэргээшийн хяналтын дүгнэлт хийх зорилгоор сэргээшийн хяналтын баталгаажсан лабораторид хандахад туслалцаа үзүүлэх үүрэг хүлээх.



### III. Олон улсын хамтын ажиллагаа

13 дугаар зүйл

#### Сэргээш хэрэглэхийн эсрэг байгууллага болон спортын байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Оролцогч улсууд энэхүү конвенцийн зорилгоор өөрсдийн хэргийн хэргийн харьяалал болон оролцогч бусад улсын хэргийн харьяаллын хүрээнд сэргээш хэрэглэхийн эсрэг байгууллага, төрийн байгууллага болон спортын байгууллага хоорондын хамтын ажиллагааг олон улсын хэмжээнд хөхиүлэг дэмжинэ.

14 дүгээр зүйл

#### Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн зорилтыг дэмжих

Оролцогч улсууд сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын тэмцэл дэх Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн чухал зорилтыг дэмжих үүрэг хүлээнэ.

15 дугаар зүйл

#### Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн тэгш санхүүжилт

Оролцогч улсууд төрийн байгууллага болон Олимпийн хөдөлгөөнөөс Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн жилийн үндсэн төсвийг тэгш санхүүжүүлэх зарчмыг дэмжинэ.

16 дугаар зүйл

#### Сэргээшийн хяналт дахь олон улсын хамтын ажиллагаа

Тамирчдад урьдчилан мэдэгдэхгүйгээр сорил хийж, сорилыг лабораторид шинжилгээ хийлгэхээр тухай бүр хүргүүлэх тохиолдолд л гагцхүү спортод сэргээш хэрэглэхийн эсрэг үр дүнтэй тэмцэнэ гэдгийг хүлээн зөвшөөрөхийн хамт оролцогч улсууд өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн дагуу хэрэв шаардлагатай гэж үзвэл дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

(a) тухайн улсын хууль тогтоомжийн дагуу өөрсдийн нутаг дэвсгэрт, эсхүл тэдгээрийн гадна байгаагаас үл хамааран тэмцээний, эсхүл



тэмцээний бус үед өөрсдийн тамирчдыг сэргээшийн хяналтад хамруулахад Дэлхийн сэргээшийн эсрэг агентлаг болон Дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж буй сэргээшийн эсрэг байгууллагад дэмжлэг үзүүлэх;

(b) сэргээшийн хяналтын үйл ажиллагааг явуулах тохиолдолд сэргээшийн хяналтын эрх бүхий багийг цаг алдалгүй улсын хилээр нэвтрүүлэх талаар дэмжлэг үзүүлэх;

(c) сорилыг улсын хилээр цаг алдалгүй тээвэрлэх, эсхүл авч гарах болон ийм арга замаар тэдгээрийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор байнга хамтран ажиллах;

(d) сэргээшийн эсрэг төрөл бүрийн байгууллагаас сэргээшийн хяналтын талаар явуулж буй үйл ажиллагааг олон улсын хэмжээнд уялдуулан зохицуулахад дэмжлэг үзүүлэх, эл зорилгоор Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагтай хамтран ажиллах;

(e) өөрсдийн хэргийн харьяалал дахь сэргээшийн хяналтын лабораториудын хооронд, эсхүл оролцогч бусад улсын хэргийн харьяалал дахь сэргээшийн хяналтын лабораториудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих. Тухайлбал, сэргээшийн хяналтын баталгаажсан лабораторидой оролцогч улсууд өөрсдийн хэргийн харьяалал дахь лабораториудаараа дамжуулан оролцогч бусад улсад өөрсдийн лабораторийг байгуулахад шаардлагатай туршлага, мэдлэг болон техникийн аргачлалыг олж авахад гаргасан хүсэлтийн дагуу туслалцаа үзүүлэх;


(f) Дүрмийн дагуу томилогдсон сэргээшийн эсрэг байгууллагуудын хоорондох харилцан шинжилгээ хийх талаар тохиролцоо байгуулах, хэрэгжүүлэх явдалд дэмжлэг үзүүлэх;

(g) сэргээшийн хяналтын журам, шинжилгээний дараахь үр дүнгийн журам, түүний дотор сэргээшийн эсрэг аливаа байгууллагаас Дүрмийн дагуу хэрэгжүүлэх спортын шийтгэлийг харилцан адил байх үндсэн дээр хүлээн зөвшөөрөх.

17 дугаар зүйл

### Сайн дурын сан

1. Цаашид “Сайн дурын сан” гэх “Спортод сэргээшийг устгах сан”-г үүгээр байгуулав. Сайн дурын сан нь ЮНЕСКО-ийн Санхүүгийн журмын дагуу байгуулсан итгэлцлийн сангаас бүрдэнэ. Оролцогч улсууд болон бусад оролцогчийн хандив нь сайн дурынх байна.




2. Сайн дурын сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар бүрдүүлнэ:
- (a) оролцогч улсуудаас үзүүлэх хандив;
  - (b) дараахь этгээдээс үзүүлж болох хандив, бэлэг, эсхүл өв хөрөнгө:
    - (i) бусад улс;
    - (ii) Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллага, хөтөлбөр, түүний дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, түүнчлэн олон улсын бусад байгууллага;
    - (iii) төрийн байгууллага, эсхүл хуулийн этгээд буюу хувь хүн;
  - (c) Сайн дурын сангийн эд хөрөнгөд ногдох хүү;
  - (d) Сайн дурын сангийн эрх ашигт зориулан зохион байгуулсан арга хэмжээнээс цуглуулсан болон хүлээн авах замаар бий болсон санхүүжилт;
  - (e) Талуудын бага хурлаас батласан Сайн дурын сангийн дүрэм, журмаар зөвшөөрөгдсөн аливаа бусад эх үүсвэр.

3. Оролцогч улсуудаас Сайн дурын санд үзүүлэх хандивыг Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн жилийн төсвийг бүрдүүлэхэд төлөх оролцогч улсуудын хувийг орлуулах байдлаар авч үзэхгүй.

18 дугаар зүйл

### Сайн дурын сангийн хөрөнгийг ашиглах, зарцуулах

Талуудын бага хурлаас батласан үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан сайн дурын сангийн хөрөнгийг энэхүү конвенцийн заалтуудын дагуу Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн зорилгыг харгалзан үзсэний үндсэн дээр сэргээшийн эсрэг хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж буй оролцогч улсуудад туслалцаа үзүүлэхэд хуваарилах бөгөөд түүнчлэн энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж болно. Сайн дурын сангаас үзүүлсэн дэмжлэгийг улс төр, эдийн засаг буюу бусад нөхцөлд хамааруулж болохгүй юм.



#### IV. Боловсрол, сургалт

19 дүгээр зүйл

##### Ерөнхий боловсрол, сургалтын нийтлэг зарчим

1. Оролцогч улсууд өөрсдийн бололцооны хүрээнд сэргээшийн эсрэг боловсрол, сургалтын хөтөлбөрийг дэмжих, боловсруулах буюу хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Спортын нийгэмлэгүүдийн хувьд ерөнхийдөө эдгээр хөтөлбөр нь дараахь асуудлаар шинэчилсэн болон бүрэн мэдээллээр хангахад чиглэгдэнэ:

(a) спортын ёс суртахуунд сэргээш хэрэглэхэд учруулж буй хохирол;

(b) сэргээшийн улмаас гарах эрүүл мэндийн үр дагавар.

2. Дээр дурдсан зүйлд нэмэлт болгон тамирчид болон тамирчдыг дэмжих ажилтан өөрсдийн анхан шатны сургалт дахь боловсрол, сургалтын хөтөлбөр нь дараахь асуудлаар шинэчилсэн болон бүрэн мэдээллээр хангахад чиглэгдэнэ:

(a) сэргээшийн хяналтын журам;

(b) сэргээшийн эсрэг тэмцэхтэй холбоотой тамирчдын эрх, үүрэг, түүний дотор Дүрмийн тухай, спортын холбогдох байгууллагууд болон сэргээшийн эсрэг байгууллагуудаас хэрэгжүүлэх сэргээшийн эсрэг бодлого, түүний дотор сэргээшийн эсрэг журмыг зөрчсөнөөс үүдэх үр дагаврын тухай мэдээлэл;

(c) хориглосон Ёдис, арга барилын жагсаалт болон хориглосон бодисыг эмчилгээний зориулалтаар хэрэглэх зөвшөөрөл;

(d) хүнсний нэмэлт тэжээл.

20 дугаар зүйл

##### Үйл ажиллагааны талаархи мэргэжлийн дүрэм

Оролцогч улсууд спортод сэргээш хэрэглэхтэй тэмцэх, түүнтэй холбогдуулан үйл ажиллагаа, сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх дадал болон ёс суртахууны талаархи дүрмийг эрх бүхий мэргэжлийн холбоод, байгууллагуудаас Дүрэмд нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх явдалд дэмжлэг үзүүлнэ.



21 дүгээр зүйл

### Тамирчид болон тамирчдыг дэмжих ажилтны оролцоо

Оролцогч улсууд спортын болон холбогдох бусад байгууллагаас сэргээшийн эсрэг хэрэгжүүлэх бүх талын үйл ажиллагаанд тамирчид болон тамирчдыг дэмжих ажилтны идэвхтэй оролцоог өөрсдийн бололцооны хүрээнд хөхиүлэн дэмжих бөгөөд эл хэрэгт өөрсдийн хэргийн харьяалал дахь спортын байгууллагуудыг татан оролцуулна.

22 дугаар зүйл

### Спортын байгууллага, сэргээшийн эсрэг байнгын боловсрол, сургалт

Оролцогч улсууд 19 дүгээр зүйлд тодорхойлсон асуудлаар бүх тамирчин болон тамирчдыг дэмжих ажилтанд зориулан байнгын боловсрол, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд спортын байгууллага, сэргээшийн эсрэг байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

23 дугаар зүйл

### Боловсрол, сургалтын хамтын ажиллагаа

Оролцогч улсууд сэргээшийн эсрэг үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай мэдээлэл, мэргэжилтэн болон туршлага солилцох зэргээр өөр хоорондоо болон холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

## V. Судалгаа

24 дүгээр зүйл

### Сэргээштэй тэмцэх асуудлаар хийх судалгаанд дэмжлэг үзүүлэх

Оролцогч улсууд өөрсдийн бололцооны хүрээнд дараахь асуудлаар спортын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах замаар сэргээштэй тэмцэх асуудлаар хийх судалгаанд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ:

(а) урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэлбэр, зан байдлын болон нийгмийн асуудал, сэргээш хэрэглэснээр гарах эрүүл мэндийн үр дагавар;



(b) тамирчны эрүүл мэндэд хохирол учруулалгүйгээр шинжлэх ухааны үндэслэлтэй физиологийн болон сэтгэл зүйн хөтөлбөр боловсруулах арга зам, хэлбэр;

(c) шинжлэх ухааны хөгжил дэвшлийн үр дүнд гарч болох бүхий л эм, бодис болон аргыг хэрэглэх.

### 25 дугаар зүйл

#### Сэргээшийн эсрэг судалгааны шинж чанар

24 дүгээр зүйлд заасны дагуу сэргээшийн эсрэг хийх судалгааг хөхиүлэн дэмжихдээ оролцогч улсууд тухайн судалгааг явуулах дараахь нөхцөлийг хангана:

(a) олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээг сахих;

(b) хориглосон бодис болон арга барилыг тамирчдад хэрэглүүлэхээс зайлсхийх;

(c) сэргээшийн эсрэг хийсэн судалгааны үр дүнг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, түүнийг сэргээшийн зориулалтаар ашиглах явдлыг таслан зогсоох талаар урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээ авах.

### 26 дугаар зүйл


#### Сэргээшийн эсрэг хийх судалгааны үр дүнг харилцан солилцох

Оролцогч улсууд хэрэв шаардлагатай гэж үзвэл, сэргээшийн эсрэг хийх судалгааны үр дүнг оролцогч бусад улс болон Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагтай үндэсний хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн хэм хэмжээний нөхцөлийн дагуу харилцан солилцоно.

### 27 дугаар зүйл

#### Спортын салбар дахь шинжлэх ухааны судалгаа

Оролцогч улсууд дараахь байгууллагуудад дэмжлэг үзүүлнэ:



46

(a) Дүрэмд заасан зарчмуудын дагуу спортын салбар дахь шинжлэх ухааны судалгааг эрдэм шинжилгээний болон эрүүл мэндийн ажилтнуудаар явуулахад;

(b) Дүрэмд заасан зарчмуудын дагуу спортын салбар дахь шинжлэх ухааны судалгааг өөрсдийн хэргийн харьяалалд хамаарх спортын байгууллага болон тамирчдыг дэмжих ажилтнуудаар явуулахад.

## VI. Конвенцийн хяналт

28 дугаар зүйл

### Талуудын бага хурал

1. Талуудын бага хурлыг үүгээр байгуулав. Талуудын бага хурал нь энэхүү конвенцийн бие даасан байгууллага байна.
2. Талуудын бага хурал зарчмын хувьд хоёр жил тутамд ердийн чуулганы хэлбэрээр хуралдана. Бага хурлын тусгай чуулганыг хэрэв оролцогч улсуудын гуравны нэгийн хүсэлтээр, эсхүл тийнхүү шийдвэрлэвэл хуралдуулж болно.
3. Оролцогч улс бүр Талуудын бага хуралд нэг саналын эрхтэй байна.
4. Талуудын бага хурал нь өөрийн үйл ажиллагааны журмыг батална.


29 дүгээр зүйл

### Талуудын бага хуралд зөвлөх байгууллага болон ажиглагчид

Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийг Талуудын бага хуралд зөвлөх байгууллагаар урьж болно. Олон улсын олимпын хороо, Олон улсын паралимпийн хороо, Европын зөвлөл болон Биеийн тамирын боловсрол, спортын засгийн газар хоорондын хороог ажиглагчаар урьж болно. Талуудын бага хурал нь бусад холбогдох байгууллагыг ажиглагчаар урихаар шийдвэрлэж болно.

30 дугаар зүйл

### Талуудын бага хурлын чиг үүрэг





1. Энэхүү конвенцийн бусад заалтад дурдсанаас гадна, Талуудын бага хурал дараахь чиг үүрэгтэй байна:

(a) энэхүү конвенцийн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

(b) Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн харилцаа, хамтын ажиллагааны талаар хэлэлцэх, Агентлагийн жилийн үндсэн төсвийн санхүүжилтийн механизмын талаар судалгаа хийх. Конвенцид оролцогч бус улсыг хэлэлцүүлэгт оролцуулахаар урьж болно;

(c) 18 дугаар зүйлийн дагуу Сайн дурын сангийн хөрөнгийг зарцуулах төлөвлөгөөг батлах;

(d) оролцогч улсуудаас хүргүүлсэн илтгэлийг 31 дүгээр зүйлийн дагуу хэлэлцэх;

(e) 31 дүгээр зүйлийн дагуу сэргээшийн эсрэг тогтолцоог боловсруулахтай холбогдуулан энэхүү конвенцийн хэрэгжилтийн хяналтыг байнгын үндсэн дээр шалгах. 31 дүгээр зүйлээс гадуур хийгдэж буй аливаа хяналтын механизм, эсхүл арга хэмжээг 17 дугаар зүйлийн дагуу байгуулсан Сайн дурын сангаар дамжуулан санхүүжүүлнэ;

(f) цаашид батлах зорилгоор энэхүү конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх;

(g) Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагаас батласан Хориглосон жагсаалт болон олгож буй эмчилгээний хэрэглээний түвшингийн стандартад оруулах нэмэлт өөрчлөлтийг конвенцийн 34 дүгээр зүйлийн дагуу батлах зорилгоор хянан үзэх;


(h) Энэхүү конвенцийн хүрээнд Оролцогч улсууд болон Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн хоорондын хамтын ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэх;

(i) Дүрмийн хэрэгжилтийн тухай илтгэлийг өөрийн чуулган бүрээр хянан үзэх зорилгоор Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагаас хүсэх.

2. Оролцогч улсуудын бага хурал өөрийн чиг үүргийг биелүүлэхдээ засгийн газар хоорондын бусад байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

31 дүгээр зүйл

**Талуудын бага хуралд оролцогч улсуудаас хүргүүлэх  
Тайлан илтгэл**



Оролцогч улсууд нь энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээнийхээ тухай холбогдох бүх мэдээллийг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан талуудын Бага хуралд 2 жилд нэг удаа ЮНЕСКО-гийн албан ёсны аль нэг хэлээр ирүүлнэ.

### 32 дугаар зүйл


#### Талуудын бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газар

1. Талуудын бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газрыг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал бүрдүүлнэ.
2. Талуудын бага хурлын хүсэлтийн дагуу ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагаас үзүүлэх үйлчилгээг Талуудын бага хурлаас зөвшилцсөн нөхцөлийн дагуу боломжийн дээд хэмжээгээр ашиглана.
3. Конвенцтой холбоотой үйл ажиллагааны зардлыг 17 дугаар зүйлийн дагуу байгуулсан Сайн дурын сангийн холбогдох түвшинд байгаа хөрөнгийн хүрээнд ЮНЕСКО-ийн ердийн төсвөөс санхүүжүүлэх, эсхүл 2 жил тутам тодорхойлох тэдгээрийн холбогдох арга хэлбэрээр санхүүжүүлнэ. Нарийн бичгийн дарга нарын газрыг ердийн төсвөөс санхүүжүүлэхдээ Конвенцийг сайн дурын хандиваар санхүүжүүлнэ гэдгийг мөн давхар харгалзан үзсэний үндсэн дээр хамгийн бага хэмжээгээр санхүүжүүлнэ.
4. Нарийн бичгийн дарга нарын газар нь Талуудын бага хурлын баримт бичиг болон хэлэлцэх асуудлыг бэлтгэх бөгөөд түүнчлэн Бага хурлын шийдвэрийн биелэлтийг хангана.

### 33 дугаар зүйл

#### Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Оролцогч улс бүр ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Ерөнхий захирал энэхүү саналыг оролцогч бүх улсад хүргүүлнэ. Энэхүү саналыг хүргүүлснээс хойш зургаан сарын дотор оролцогч улсуудын талаас илүү хувь нь уг саналыг дэмжсэн хариу ирүүлбэл Ерөнхий захирал саналыг Талуудын бага хурлын дараагийн чуулганаар хэлэлцүүлнэ.
2. Талуудын бага хурал нь нэмэлт өөрчлөлтийг санал хураалтад байлцсан болон оролцсон оролцогч улсуудын гуравны хоёроос дээш хувийн саналаар батална.



3. Энэхүү конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батласны дараа түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу түүнд нэгдэн орох зорилгоор оролцогч улсуудад хүргүүлнэ.

4. Нэмэлт өөрчлөлт нь зөвхөн түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу түүнд нэгдэн орсон улсуудын хувьд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу оролцогч улсуудын гуравны хоёр нь дурдсан баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Харин нэмэлт өөрчлөлтийг цаашид соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу түүнд нэгдэн орох оролцогч улс бүрийн хувьд энэхүү нэмэлт өөрчлөлт нь оролцогч тухайн улсаас соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа энэхүү конвенцийн оролцогч болсон улсын хувьд тэрээр өөр аливаа чиг санаа илэрхийлээгүй бол түүнийг:

(a) нэмэлт өөрчлөлт оруулсан энэхүү конвенцийн оролцогч;

(b) эдгээр нэмэлт өөрчлөлттэй холбоогүй оролцогч аливаа улсын хувьд энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулаагүй оролцогч гэж үзнэ.

34 дүгээр зүйл

### Конвенцийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тусгай журам

1. Хэрэв Дэлхийн сэргээшийн эсрэг агентлаг Хориглосон жагсаалт болон Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох стандартад өөрчлөлт оруулбал энэ тухайгаа Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэж болно. Ерөнхий захирал эдгээр өөрчлөлтийг Конвенцийн холбогдох хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах саналын хэлбэрээр оролцогч бүх улсад шуурхай мэдэгдэнэ. Хавсралтад оруулах нэмэлт өөрчлөлтийг Талуудын бага хурлын аль нэг чуулганаар, эсхүл бичгээр зөвшилцөж батлана.

2. Оролцогч улсууд санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн эсрэг саналтай байгаагаа Ерөнхий захирлын мэдэгдсэн өдрөөс хойш 45 хоногийн дотор зарлах, эсхүл бичгээр зөвшилцөж байгаа тохиолдолд Ерөнхий захирлын нэр дээр бичгээр мэдээлэх, эсхүл Талуудын бага хуралд мэдэгдэнэ. Хэрэв оролцогч улсын гуравны хоёр нь эсрэг саналтайгаа



илэрхийлээгүй бол санал болгож буй нэмэлт өөрчлөлтийг батлагдсанд тооцно.

3. Ерөнхий захирал Талуудын бага хурлаар батласан нэмэлт, өөрчлөлтийн талаар оролцогч улсуудад мэдэгдэнэ. Энэ нэмэлт өөрчлөлт нь тийнхүү мэдэгдсэн өдрөөс хойш 45 хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд харин энэ нэмэлт өөрчлөлтийг хүлээж авахгүй гэдгээ Ерөнхий захиралд урьд нь мэдэгдсэн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болохгүй.

4. Дээрх заалтуудын дагуу батлагдсан нэмэлт өөрчлөлтийг хүлээж авахгүй гэдгээ Ерөнхий захиралд мэдэгдсэн оролцогч улсын хувьд нэмэлт өөрчлөлт оруулаагүй хавсралтын үйлчлэл хэвээр үлдэнэ.

### VII. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

35 дугаар зүйл

#### Холбооны буюу нэгдмэл бус үндсэн хуулийн тогтолцоо

Холбооны буюу нэгдмэл бус үндсэн хуулийн байгуулалттай оролцогч улсууд дараахь заалтыг хэрэглэнэ:


(a) холбооны буюу хууль тогтоох төв засаглалын хэргийн харьяаллын хүрээнд хэрэглэх энэхүү конвенцийн заалтуудын хувьд холбооны буюу төв засгийн газрын хүлээх үүрэг нь холбооны бус оролцогч улсуудын үүрэгтэй нэг адил байна;

(b) холбооны үндсэн хуулийн тогтолцооны дагуу хууль тогтоох үүрэггүй, холбооны бие даасан бүрэлдэхүүн болсон муж, хязгаар болон кантоны хэргийн харьяаллын хүрээнд хэрэглэх энэхүү конвенцийн заалтуудын хувьд холбооны засгийн газар нь эдгээр муж, хязгаар болон кантоны эрх бүхий байгууллагуудад дээрх заалтууд болон тэдгээрийг батлах тухай зөвлөмжийн хамт мэдэгдэнэ.

36 дугаар зүйл

#### Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох

Энэхүү конвенцийг ЮНЕСКО-ийн гишүүн улсууд Үндсэн хуулийнхаа холбогдох журмын дагуу соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах бөгөөд эсхүл түүнд нэгдэн орно. Соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн батласан болон нэгдэн орсон тухай баримт бичгийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулахаар хүргүүлнэ.



37 дугаар зүйл

**Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон батласан батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, батласан болон нэгдэн орсон тухай 30 дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш нэг сарын хугацаа дууссан анхны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү конвенцийн дагуу үүрэг хүлээх тухайгаа дараа нь зарласан аль ч улсын хувьд соёрхон батласан батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, батласан болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш нэг сарын хугацаа дууссан анхны өдрөөс эхлэн Конвенц хүчин төгөлдөр болно.

38 дугаар зүйл

**Конвенц үйлчлэх нутаг дэвсгэр**

1. Аливаа улс конвенцийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн батласан болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөхдөө олон улсын харилцааных нь төлөө хариуцлага хүлээх болон Конвенцийн үйлчлэлд хамаарах нутаг дэвсгэр болон нутаг дэвсгэрүүдийг нэрлэн зааж болно.
2. Аливаа оролцогч улс ЮНЕСКО-д хандсан мэдэгдлийнхээ сүүлийн шатанд энэхүү мэдэгдэлдээ дурдсан аливаа нутаг дэвсгэрийг энэхүү конвенцийн үйлчлэлийн хүрээнд хамааруулж болно. Конвенц нь ийм мэдэгдлийг эх хадгалагч хүлээж авсан өдрөөс хойш нэг сарын хугацаа өнгөрсний дараагийн сарын анхны өдрөөс эхлэн тухайн нутаг дэвсгэрийн хувьд хүчин төгөлдөр болно.
3. Дээрх хоёр заалтын дагуу хийсэн аливаа мэдэгдлийг уг мэдэгдэлд дурдсан аливаа нутаг дэвсгэрийн хувьд ЮНЕСКО-д мэдэгдэл илгээх замаар эргүүлэн татаж болно. Ийнхүү эргүүлэн татсан нь эргүүлэн татах тухай мэдэгдлийг эх хадгалагч хүлээж авсан өдрөөс хойш нэг сарын хугацаа өнгөрсний дараагийн сарын анхны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Handwritten notes and stamps at the bottom of the page, including a signature and the number 11.

39 дүгээр зүйл

Цуцлах

Оролцогч улс бур энэхүү конвенцийг цуцалж болно. Цуцлалтыг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулна. Цуцлалт нь цуцалсан тухай баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын хугацаа өнгөрсний дараагийн сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно. Цуцлалт нь холбогдох оролцогч улсын Конвенцоос гарсан нь хүчин төгөлдөр болсон хугацаа хүртэлх санхүүгийн үүрэгт аль ч байдлаар нөлөөлөхгүй.

40 дүгээр зүйл

Эх хадгалагч

Энэхүү конвенцийг болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал хадгална. ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал эх хадгалагчийнхаа хувьд энэхүү конвенцийн оролцогч улсууд болон байгууллагын гишүүн бусад улсад:

(a) соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн батласан болон нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн;

(b) энэхүү конвенц түүний 37 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болсон;

(c) 31 дүгээр зүйлийн дагуу бэлтгэсэн аливаа илтгэл;

(d) конвенцид эсхүл хавсралтуудад оруулсан, 33 болон 34 дүгээр зүйлийн дагуу батлагдсан аливаа нэмэлт өөрчлөлт болон тэдгээрийн хүчин төгөлдөр болсон огноо;

(e) 38 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн аливаа хүсэлт, мэдэгдэл;

(f) 39 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлсэн аливаа мэдэгдлийн тухай болон хүчингүй болгосон нь хүчин төгөлдөр болсон огноо;

(g) энэхүү конвенцтой холбоотой аливаа акт, мэдэгдэл, мэдээллийн тухай мэдэгдэнэ.



41 дүгээр зүйл

**Бүртгэл**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

42 дугаар зүйл

**Адил хүчинтэй эх бичвэр**

1. Энэхүү конвенц болон түүний хавсралтуудыг англи, араб, испани, хятад, орос, франц хэлээр үйлдсэн бөгөөд зургаан эх бичвэр адил хүчинтэй.
2. Энэхүү конвенцийн нэмэлтийг англи, араб, испани, хятад, орос, франц хэлээр үйлдсэн.

43 дугаар зүйл

**Тайлбар**

Энэхүү конвенцийн зохицуулах зүйл болон зорилгод харш ямар ч тайлбар хийхийг үл зөвшөөрнө.



I ХАВСРАЛТ

2007 ОНД ХОРИГЛОСОН ДОПИНГИЙН ЖАГСААЛТ

(ОЛОН УЛСЫН ДОПИНГИЙН ЭСРЭГ ТӨВ)

Тэмцээний үед болон тэмцээнээс гадуур хэрэглэхийг хориглосон эмийн бодисууд ба аргууд:

Хориглосон бодисууд:

S1. Анаболик бодисууд хориглогдсон

1. Анаболик андрогеник стероидууд /AAS/

(a) Экзоген гаралтай AAS

- 1-Андростендол /5α-андрост 1 энэ -3 β.17 β -диал/
- 1- андростендионе /5α-андрост 1 энэ -3.17 -дионе/
  - боландиол /19-норандростенедиол/
  - боланстерионе
  - болденоне
  - болдионе /андроста -1.4- диэне-3.17-дионе/
  - калустероне
  - дегидрохлорметилтестостероне /4 хлоро-17 β-гидроокси-17 α метиландроста -1.4- диен -3-оне/
  - дезооксиметилтестостероне /17 α-метил - 5 α-андрост -2-ен-17 β-ол/
  - дростанолоне
  - этилэстренол /19-нор-17 α прегн-4-ен-17-ол/
  - флуоксиместероне
  - формеболоне
  - фуразабол /17 β-гидрокси-17 α-метил-5 α-андростано [2.3-с]-фуразон/
  - гестриноне
- /4-гидрокситестостероне-4.17 β дигидроксиандрост -4-эн-3-оне/
  - местанолоне
  - местеролоне
  - метенолоне
  - - метандиеноне /17 β-гидрокси-17 α-метиландроста-1.4-диен-3-оне/
  - метандриол

Монгол Улсын Гадаад Хэргийн Яам  
 Албан ёсны орчуулга мөн  
 Гарын үсэг /Signature/ .....  
 2007 оны 6 сарын 11 өдөр  
 Улаанбаатар хот

Ministry for Foreign Affairs of Mongolia  
 No. 24, 12th Floor, Ulaanbaatar



- метастероне /2 α 17 α –диметил -5 α –андростане –3-оне-17 β -ол/
- метилдинолон /17 β -гидрокси- 17 α –метилэстра-4,9-диен-3-они/
- -метил-1- тестостерон /17 β -гидрокси- 17 α –метил-5 α андрост-1-ин-3-они/
- метилнортостерон /17 β -гидрокси- 17 α –метилэстра-4 ин-3-они/
- метилтриэнолони /17 α -гидрокси- 17 α –метилэстра-4,9,11-триен-3-они/
- метилтестостерон
- миболерон
- надролон
- 19- норандростенедиони /эстра-4-ини-3,17-диони/
- норболетони
- норкlostебол
- норэфандролони
- оксаболони
- оксандролони
- оксиместерони
- оксиметолон
- простанозол /[3,2-с] пиразол 5α –этиоаллохолани –17α-тетрагидропиранол/
- квинболон
- станозолол
- стенболон
- -1-тестостерон /17 β -гидрокси- 5α –андрост-1-ин-3-они/
- тетрагидрогистринон /18α -гомо-прегна-4,9,11-триен- 17 β-ол-3-они/
- тринболон болон бусад бодис /химийн ижил бүтэц ба биологийн ижил үйлчилгээтэй /

### (b) Эндогенний AAS

- андростенедиол /андрост –5-ини-3 β,17 β -диоол/
- андростенедиони /андрост –4-ини-3 ,17 -диони/
- дигидротестостерон /17 β -гидрокси- 5α –андростан -3-они/
- прастерон /дигидроэпиандростерон, DHEA/
- тестостерон ба метаболитик изомерүүд
- 5 α -андростан-3 α ,17 α -диоол
- 5 α -андростан-3 α ,17 β –диоол
- 5 α -андростан-3 β ,17 α –диоол
- 5 α -андростан-3 β ,17 β –диоол
- андрост -4-ини-3 α ,17 α -диоол
- андрост -4-ини-3 α ,17 α –диоол
- андрост -4-ини-3 α ,17 β –диоол



- андрост -5-ини-3 α ,17 α –диол
- андрост -5-ини-3 α ,17 β –диол
- андрост -5-ини-3 β ,17 α –диол
- 4- андростенедиол /андрост –4-ини-3 β ,17 β –диол/
- 5- андростенедионе /андрост –5- ини-3.17-диол/
- эпи-дигидротестостерон
- 3 α- гидрокси- 5 α-андростан –17 они
- 3 β - гидрокси- 5 α-андростан –17 они
- 19-норандростерон
- 19-норэтиохоланол


Андрогений стероидный аналитикүүд нь эндогенийг үүсгэх бөгөөд хориглосон сорьцын найрлаганд ордог. Хориглосон бодисын нөлөөгөөр метаболизмын маркер , бие махбодийн бодисын үзүүлэлтэд хамаатай тоон харьцаа хэвийн байдлаас өөрчлөгдөх ба хэвийн эндогений найрлагаас өөр болно. Дээрх бодис нь хориглосон эмийн найрлаганд харагдахгүй юм шиг мөртлөө хориглосон эмийн метаболизмын явцыг гүйцэтгэх суурь нь болж өгдөг. Ихэнх суурь эм, түүний концентраци организмын бодисын найрлаганд байдаг ба лабораторийн шинжилгээгээр илэрдэг (Сөрөг аналитик судалгаа).

Лабораторийн шинжилгээнд T/E –ийн хэмжээ 4-өөс 1-рүү ихэссэн байвал бас бодисын экзогений гаралтай бодис илрэхгүй бол шинжилгээг дахин буюу дараагийн шинжилгээгээр илрүүлж болно. Хэрэв лабораторийн шинжилгээний дүнд нэмэлт аналитик аргыг хэрэглэсэн бол, хориглосон бодисын экзогений гаралтайг шинжилсэн бол хориглосон бодисыг сорьцын найрлаганд илэрлээ гэж үзнэ.

Нэмэлт аналитик судалгаагаар илрээгүй шинжилгээг 3 удаа явуулахад хамгийн бага хэмжээгээр илэрсэн бол 3 сарын хугацаанд допингийн байгууллагад шинжилгээний хариуг өгнө. Хэрэв уртасгасан шинжилгээгээр хэвийн физиологийн үзүүлэлт биш бол (сөрөг) аналитик судалгааг хийж шинжилнэ. Гадаад тохиромжтой суурь болденон нь эндогений гаралтай хамгийн бага хэмжээгээр буюу нанограм/миллитр (ng/ml) хэмжээгээр шээсэнд илэрнэ. Хэрэв хамгийн бага хэмжээтэй концентрацитай болденог нь лабораторийн болон аналитик судалгаагаар экзогений орчинд ч гэсэн илрэхгүй байх магадлалтай.

Нэмэлт аналитик судалгаагаар илрэхгүй, уртасгасан хугацааны шинжилгээнд 3 сараас хэтрэлгүй шилжүүлэх хэрэгтэй. Ингээд уртасгасан судалгаагаар хэвийн физиологийн биш гэсэн хариу илэрвэл аналитик сөрөг гэж үзнэ.

Лабораториор 19норандростероне (сөрөг А илэрсэн) бол хориглосон бодис (экзоген гаралтай) байгаа үүнийг анхаарах хэрэгтэй гэсэн үг юм.



2. Бусад анаболикүүд агуулсан боловч хязгааргүй.

Кленбутерол, тиболон, зеранол, зелфатерол  
Зориудаар экзоген гаралтай бодис мөртлөө организмд ороод хэвийн болон хувирах чадвартай. Эндогений хэвийн байдлаар организмд байдаг.

### S2.Гормонууд

Биеийн гормонтой ижил химийн найрлагатай, биологийн үйлчилгээтэй, эсхүл хориглосон бодисыг чөлөөлөх үйлчилгээтэй гормон орно.

- эритропоэтин (EPO)
- өсгөвөр гормон (hGH)
- инсулин төст өсгөвөрлөгдсөн факторс (е.д.IGF-1)
- механик өсгөвөр фактор (MGFs)
- гонадотрофин
- инсулин
- кортикотрофин

Лабораторийн шинжилгээнд аналитик судалгаа хэрэглээд экзоген гаралтай хориглосон эм хэрэглэсэн бол хориглосон эмийн найрлага хэрэглэсэн гэж үзээд аналитик илэрсэн гэнэ. Мөн химийн ижил бүтэцтэй, биологийн ижил үйлчилгээтэй, маркерийн шинжилгээгээр бодисын суллах фактор илэрсэн (гормон) бол экзогений гаралтай субстенц байгаа гэж үзээд аналитик сөрөг +/- гэж үзнэ.

### S3. BETA-2 агонист

Бүх Вета-2 түүний D болон Лизомерүүдийг хориглосон байдаг. Үүнд: формотерол, сальбутамол, сальметерол, мөн тербуталин Сальбутамолын концентраци 1000 ng/ml –ээс их байвал аналитик сөрөг +/- гэж үзээд амьсгалын замаар сорох байдлаар хэрэглэсэн гэж үзнэ.

### S4. Анти –эстроген идэвхжүүлэгч

1.анастрозол, летрозол, аминоглютемид, экземестан, форместан, тестолактон;

2. эстрогений рецептор модулятор ралоксифин, тамоксифен, торемифен;



3. бусад- кломипен, циклопен, фульбестрант.

### S5. Диуретикүүд

Бусад химийн бүтэц, биологийн үйлчилгээ ижил бодисууд:

- диуретикс
- эпитестостерон
- пробенецид
- альфа- редуктэс-ингибиторс
- плазма экспандерс /албумин, декстран,
- ацетазоламид
- амилорид
- буметанид
- канренон
- хлорталидон
- этакрин ацид
- фурасимед
- индапамид
- метолазон
- спиролактон
- тиазид
- триамтирин

### ХОРИГЛОГДОХ АРГУУД

#### M1. Оксигенийг зөөвөрлөлтийг нэмэгдүүлэх

1. Цус- ауто, ижил, гетеро цус, эсхүл улаан эсийн бүтээгдхүүний гаралтай;
2. Оксигений зөөвөрлөлтийг нэмэгдүүлэх , хэмжээ нь тодорхойгүй;
3. эфипроксирал /RSR13/, гемоглобин бүтээгдхүүнийг хувиргагчид.

#### M2. Химийн болон физиологийн манипуляцууд

1. судсаар хийгдсэн эмчилгээний төрлүүд;
2. катетр болон шээсний замаар хийгдсэн эмчилгээний төрөл



### МЗ. Допингийн ген


Эсийн түвшинд эмчилгээний төрлөөр биш ген, гений элемент, гений модулятор.

### S6. Стимулиантууд

Бүх стимулянтууд, D ба L изомерүүд

- |                            |                          |
|----------------------------|--------------------------|
| -адрарфин                  | -фурфенорекс             |
| -адреналин                 | -гентаминол              |
| -амфипрамон                | -изомелиптин             |
| -амфиназол                 | -левмитамфитамин         |
| -амфитаминал               | -меклофеноксит           |
| -бензитамин                | -мефинорекс              |
| -бромантан                 | -мефинтермин             |
| -карфедон                  | -мезокарб                |
| - кафеин                   | -метамфетамин /D/        |
| - клобензорикс             | -метилинидиоксиамфитамин |
| - кокайн                   | -                        |
| метилинидиоксиметамфетамин |                          |
| - кропропамид              | -p-метиламфитамин        |
| - кротетамид               | -метилэфидрин            |
| - циклозадон               | -метилфенидат            |
| - диметиламфатамин         | -модафинил               |
| - эфидрин                  | -найкфамид               |
| - этамиван                 | -норфинифрин             |
| - этиламфитамин            | -норфинфлураамид         |
| - этилэфидрин              | -октапамин               |
| - фампрофазон              | -ортетамин               |
| - финбутразат              | -оксилофрин              |
| - финкамфамин              | -парагидроксиамфитамин   |
| - финэтилин                | -пемолин                 |
| - финфлурамин              | -пентитразол             |
| - финпропорекс             | -финдиметразин           |
| - -финметразин             | -финпромефамин           |
| - финтирмин                | -пролинтан               |
| - пропилогексидрин         | -силигелин               |
| - сибутрамин               | -стрихинин               |

2007 оны бодисын мониторинг программд /бупропион, каффейн, пенилэфрин, пенилпрофаноламин, пипрадол, пиезоэфидрин, синефрин/-ийг хорилогдсон бодисын бүртгэлд чухалчилж тоогоогүй.



Адерналиныг өвчин намдаах үед /хамар, нүдний/ хэрэглэснийг хориглоогүй. Катин харин шээсэнд 5 микрограмм/ мл –ээс их байхыг хориглосон байна. Эфидрин ба метилэфидрин шээсэнд 10 мк/мл-ээс их байхыг хориглосон.

**S7. Наркотик**

- бупринорфин
- декстроморамид
- диаморфин /геройн/
- фентанил ба түүний төрөл
- оксиморфон
- петидин
- метадон
- морфин
- гидроморфин
- оксикодон
- пентазоцин

**S8. Каннабойд**

- гашиш
- марихуан

**S9. Гликокортикостериодууд**

Бүх гликокортикостериодуудыг амаар, шулуун гэдсээр, судсаар, булчинд хийхийг хориглосон ба эмчилгээнд хэрэглэхгүй байвал зохимжтой.

Бусад үенд, үений орчим, эпидурал, интродермал, тариагаар болон амьсгалын замаар эмчилгээнд хэрэглэсэн гэсэн заалт байдаггүй.


Арьсны эмчилгээнд (ионы болон фонофорез) чихний дэлбээ, хамар, нүд, хацар, хэл зэрэг нь хориглогдоогүй болно.

**Тусгай спортын төрлүүдэд хориглосон бодисууд:**

**P1 Спиртийн төрлийн бодисууд: (архи)**

Алкоголийг (этанол) зөвхөн уралдаан тэмцээний үеэр дараах спортын төрөлд хэрэглэхийг хориглор ба түүнийг амьсгалын болон (эсхүл) цусны шинжилгээгээр илрүүлнэ. Энэ бодисын допингийн зөрчил хэмээн үзэх доод хэмжээг спортын холбоо тус бүрээр дор тодорхойлсон байна.

- Агаарын спорт – 0.20 g/l
- Байт харваа – 0.10 g/l
- автомашин – 0.10 g/l



Боулинг – 0.10 g/l  
Каратэ – 0.10 g/l  
Орчин үеийн 5 төрөл – 0.10 g/l  
Моторт дугуй. Мотоцикл – 0.10 g/l  
Эрчимт завь – 0.30 g/l

## P2 Вета хоригууд

Бусад өвөрмөц бодисууд, вета хориг тогтоогч бодисуудыг доорхи спортын төрлүүдэд зөвхөн тэмцээний үед хориглоно.

-Агаарын спорт  
-байт харваа  
-автомашин  
-биллиард  
-бобслейн  
-боулинг  
-курлинг  
-гимнастик  
-мотоцикл  
-орчин үеийн буудлагын 5 төрөл  
-далбаат онгоц  
-буудлага / тэмцээнээс гадуур хориглоно./  
-цана, тэшүүр  
-бөх


## Вета хоригууд:

Ацебутал	карведилол	надолол
алпренолол	целипролол	оксипренолол
атенолол	есмолол	пиндолол
Бетаксоллол	лабеталлол	пропранолол
висопролол	левобунолол	соталлол
бунолол	метипранолол	тимолол
картеолол	метопролол	


## Өвөрмөц бодисууд

Өвөрмөц бодисуудыг доор жагсаавал:

кадине, кропропамид, кротетамид, эфидрин, этамиван, фампрофазон, гептаминол, изометептен, левметамфетамин,



меклофеноксат, р-метилампетамин, метилэфидрин, никетамид,  
норфенэфрин, октопамин, ортетамин, оксилофрин,  
пенпрометамин, пропилгекседрин, селегилин, сибутрамин,  
туаминогептан,

МОНГОЛ УЛСЫН Гадаад Хэргийн Яам  
Ардан асны орчуулга мөн  
Гарын үсэг (Signature)   
2017 оны 6 сарын 11 өдөр  
Улаанбаатар хот  
Ministry for Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION



## II ХАВСРАЛТ

### ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГООР ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СТАНДАРТ

Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох

**Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн (ДСЭА)  
“ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГООР ХОРИГЛОСОН БОДИС ХЭРЭГЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ”-ын хэсгээс  
(2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон)**

#### 4.0 Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох олгох шалгуурууд

Тамирчинд эмчилгээний зорилгоор *Хориглосон жагсаалтанд* орсон *хориглосон бодис, эсхүл, хориглосон арга барил* ашиглахыг зөвшөөрч (ЭЗЗ) болно. ЭЗЗО-ийн өргөдлийг Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох хороо (ЭЗЗОХ) хянаж үзнэ. *Сэргээшийн эсрэг байгууллага* нь ЭЗЗОХ-г сонгоно. Зөвшөөрлийг зөвхөн дараахь шаардлагад хатуу нийцүүлэн олгож болно:


[Тайлбар: Энэхүү стандарт нь Дүрмээр тодорхойлогдсон, түүний үйлчлэх эрүүл болон хөгжлийн бэрхшээлтэй бүх тамирчинд үйлчилнэ. Энэхүү стандарт нь хувь хүний нөхцөл байдалтай уялдаатайгаар үйлчилнэ. Жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй тамирчинд олгох зөвшөөрөл нь бусад тамирчинд тохирохгүй байж болно.]

4.1 Тамирчин нь Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл хүссэн тухай өргөдлийг спортын арга хэмжээнд оролцохоосоо 21-ээс доошгүй хоногийн өмнө гаргана.

4.2 Хүнд, эсхүл архаг өвчний байдлыг эмчлэх явцад *хориглосон бодис, эсхүл хориглосон арга барил* хэрэглэх явдлыг хориглох нь Тамирчны эрүүл мэндийг их хэмжээгээр доройтуулахад хүргэдэг.

4.3 *Хориглосон бодис, эсхүл хориглосон арга барилыг* эмчилгээнд хэрэглэх явдал нь тухайн бодисыг хэрэглэсний дүнд эрүүл мэнд хэвийн байдалдаа эргэж орох эмчилгээний үр нөлөөнөөс өөрөөр спортын илүү амжилтыг бий болгох нөлөө үзүүлэх ёсгүй. Аливаа хэвийн түвшнээс доогуур эндогэнний гормоны түвшинг өсгөхийн тулд *хориглосон бодис, эсхүл хориглосон арга барил* хэрэглэх нь хүлээн зөвшөөрөхүйц эмчилгээний арга гэж тооцогдохгүй.

4.4 *Хориглосон бодис, эсхүл хориглосон арга барилын* хэрэглээтэй дүйцэхүйц төрлийн эмчилгээний боломжит хэлбэр гэж үгүй.



4.5 Хориглосон бодис, эсхүл хориглосон арга барилыг хэрэглэх шаардлага нь хориглосон жагсаалтанд орсон бодисыг эмчилгээний бус зорилгоор өмнө нь бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэглэсний үр дагавар байж чадахгүй.

4.6 ЭЗЗ-ийг дараахь тохиолдлуудад олгосон байгууллага нь цуцална:

(a) зөвшөөрөл олгосон *Сэргээшийн эсрэг байгууллагын* тавьсан нөхцөл, эсхүл шаардлагыг *тамирчин* шууд дагаж биелүүлэхгүй байвал;

(b) ЭЗЗО-ийг олгосон хугацаа дууссан;

(c) *Сэргээшийн эсрэг байгууллага* ЭЗЗ-ийг хураан авах болсон тухайгаа *Тамирчинд* мэдэгдсэн.

[Тайлбар: ЭЗЗ бүр ЭЗЗОХ-оос шийдвэрлэсэн тодорхой хугацаатай байна. ЭЗЗ-ийн хугацаа дууссан, эсхүл түүнийг хураан авсан боловч ЭЗЗ-д хамаарах хориглосон бодис тамирчны биед байх тохиолдлууд байдаг. Энэ тохиолдлуудад сөрөг үр дүнг анхлан хянасан Сэргээшийн эсрэг байгууллага тухайн нөхцөл байдал нь ЭЗЗ-ийн хугацаа дууссан, эсхүл түүнийг хүчингүй болгосонтой нийцэж байгаа эсэхийг хэлэлцэнэ.]

4.7 Эмчилгээний зориулалтаар зөвшөөрөл хүссэн өргөдөлд дор дурдсанаас бусад тохиолдолд нөхөн зөвшөөрөл олгохгүй:


(a) хойшлуулшгүй эмчилгээ, эсхүл хүнд өвчнийг эмчлэх зайлшгүй шаардлага байсан;

(b) онцгой нөхцөл байдлын улмаас *сэргээшийн хяналтаас* өмнө өргөдөл гаргагчдад мэдүүлэх, эсхүл ЭЗЗОХ-нд хэлэлцэх хангалттай хугацаа, эсхүл бололцоо байгаагүй.

[Тайлбар: ЭЗЗ-ийн өргөдлийг гаргахаас өмнө Хориглосон бодис эсхүл Хориглосон аргын хэрэглээ шаардсан эрүүл мэндийн онцгой байдлууд эсхүл эрүүл мэндийн хүнд нөхцөлүүд гарах тохиолдлууд байдаг боловч ховор. Үүнтэй адилаар, тэмцээний хугацаа ойртсон үед ЭЗЗ хүссэн өргөдлийг түргэвчилсэн байдлаар хэлэлцэхийг шаардсан тохиолдлууд бас ховор. ЭЗЗ олгогч Сэргээшийн эсрэг байгууллагууд нь эдгээр тохиолдлыг хэлэлцэн шийдвэрлэхийг зөвшөөрсөн дотоодын журамтай байх ёстой.]

5.0 Мэдээллийн нууц

5.1 Өргөдөл гаргагч нь өргөдөлд хамааралтай бүх мэдээллийг ЭЗЗОХ-ны гишүүдэд, шаардлагатай тохиолдолд бусад бие даасан эмнэлгийн, эсхүл



шинжлэх ухааны шинжээчдэд, эсхүл ЭЗЗ-ийг хэлэлцэх, давж заалдах, болон удирдах үйл явцад оролцож буй шаардлагатай гэсэн албан хаагчдад шилжүүлэн өгч болно гэсэн бичгэн зөвшөөрлийг гаргаж өгөх үүрэгтэй.

Бие даасан, гадны шинжээчдийн зөвлөгөө шаардлагатай бол *Тамирчин болон түүнийг эмчилж буй эмчийн* нэрийг нууцлан өргөдлийн бусад бүх мэдээллийг тарааж болно. Түүнчлэн өргөдөл гаргагч нь Дүрэмд заасны дагуу ЭЗЗОХ шийдвэрүүдийг *Сэргээшийн эсрэг* холбогдох бусад *байгууллагуудад* тарааж болно гэсэн бичгээр үйлдсэн зөвшөөрлийг гаргаж өгнө.

5.2 ЭЗЗОХ-ны гишүүд болон *Сэргээшийн эсрэг байгууллагын* захиргаа нь өөрсдийн үйл ажиллагаагаа маш нууц байдалд явуулна. ЭЗЗОХ-ны бүх гишүүн болон оролцогч ажилтнууд нууцлалын тухай гэрээнд гарын үсэг зурна. Ялангуяа тэдгээр нь дараахь мэдээллийг нууцална:

(a) тамирчныг эмчилж буй эмч (нар)-ээс болон *Тамирчнаас* гаргаж өгсөн өгсөн эрүүл мэндийн бүх мэдээлэл болон тоо баримт;


(b) өргөдлийн бүх мэдээлэл, түүний дотор ажиллагаанд оролцогч эмч (нар)-ийн нэр, ЭЗЗОХ, эсхүл ДСЭА-гийн ЭЗЗОХ нь тамирчны нэрийн өмнөөс түүний эрүүл мэндийн талаар аливаа мэдээлэл авах эрхтэй гэж үзвэл энэ талаар *Тамирчин* өөрийн эмчид бичгээр мэдэгдэнэ. Ийм шийдвэр гаргасан бол Тамирчин нь ЭЗЗ-ийн зөвшөөрөл, эсхүл хүчин төгөлдөр буй ЭЗЗ-ийн шинэчилсэн байдлаар хүлээн авахгүй.

6.0 *Эмчилгээний зориулалтаар зөвшөөрөл олгох хороонууд (ЭЗЗОХ-д)*

ЭЗЗОХ-д дор дурдсан зааварчилгааны дагуу үйл ажиллагаагаа явуулж, байгуулагдана:

6.1 ЭЗЗОХ-д наад зах нь Тамирчинд эмчилгээ хийх болон эмчилгээний ажлын туршлагатай, эмнэлгийн, спортын эмчилгээний болон эмийн хэрэглээний өндөр мэдлэгтэй гурван эмчтэй байна. Бие даасан шийдвэр гаргах баталгааг хангах үүднээс ЭЗЗОХ-ны гишүүдийн олонхи нь *Сэргээшийн эсрэг байгууллагын* өмнө албан ёсны аливаа үүрэг хүлээхгүй байх ёстой. ЭЗЗОХ-ны бүх гишүүн ашиг сонирхлын зөрчлийн гэрээнд гарын үсэг зурна. Хөгжлийн бэрхшээлтэй *Тамирчинтай* холбогдсон өргөдлүүдийг хэлэлцэхэд наад зах нь ЭЗЗОХ-ны нэг гишүүн хөгжлийн бэрхшээлтэй Тамирчдын эмчилгээний онцлог болон эмчилгээний өндөр туршлагатай байна.

6.2 ЭЗЗОХ-д нь ЭЗЗ хүссэн аливаа тодорхой өргөдлийн нөхцөл байдлуудыг хэлэлцэх үедээ шаардлагатай гэж үзсэн эмнэлгийн, эсхүл



шинжлэх ухааны судалгааны гадаад эх сурвалжийг ашиглах талаар хүсэлт гаргаж болно.

6.3 ДСЭА-гийн ЭЗЗОХ-г 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалгуурын дагуу бүрдүүлнэ. ДСЭА-гийн ЭЗЗОХ нь *Сэргээшийн эсрэг байгууллагаас* ЭЗЗ олгосон шийдвэрүүдийг өөрийн санаачилгаар хянахаар байгуулагдаж болно. Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4-т заасанчлан ДСЭА-гийн ЭЗЗОХ нь *Сэргээшийн эсрэг байгууллагаас* ЭЗЗ-ийг татгалзсан бол *Тамирчдын* хүсэлтээр тийм шийдвэрүүдийг өөрчлөх эрхтэйгээр хянан хэлэлцэж болно.

#### 7.0 ЭЗЗ хүссэн өргөдлийг хэлэлцэх ажиллагаа

7.1 ЭЗЗ-ийг холбогдох бүх материалыг агуулсан, бүрэн гүйцэд бөглөсөн өргөдлийн маягтыг (I хавсралтын ЭЗЗ-ийн маягтыг үз) хүлээн авсны дараагаар хэлэлцэнэ. Өргөдлийг эрүүл мэндийн нууцыг чандлан хадгалах зарчимд тулгуурлан хэлэлцэнэ.

7.2 I хавсралтад заасан ЭЗЗ хүссэн өргөдлийн маягтыг *Сэргээшийн эсрэг байгууллагууд* мэдээлэл авах нэмэлт хүсэлтийг агуулах зорилгоор нэг ч хэсэг, эсхүл зүйлийг хасахгүйгээр өөрчилж болно.

7.3 Хэдийгээр ЭЗЗ хүссэн өргөдлийн маягтыг *Сэргээшийн эсрэг байгууллагууд* өөр хэл үрүү орчуулж болох боловч Франц болон англи нь өргөдлийн маягт дээр үлдэх ёстой.

7.4 *Тамирчин* нь ЭЗЗ авахаар нэгээс дээш *Сэргээшийн эсрэг байгууллагад* хандаж болохгүй. Тамирчин нь спортын төрөл, шаардлагатай тохиолдолд дэг спортын журам болон тодорхой байршил, эсхүл үүргийг өргөдөлд тусгах үүрэгтэй.

7.5 Өргөдөл нь *хориглосон бодис*, эсхүл *хориглосон арга* барил хэрэглэх зөвшөөрөл авахаар гаргаад буй болон урьд гаргасан хүсэлтүүд, хүсэлтийг гаргасан байгууллага, тэдгээр байгууллагын шийдвэрийг жагсаасан байна.

7.6 Өргөдөлд хамааралтай эрүүл мэндийн дэлгэрэнгүй түүх, бүх үзлэгийн үр дүнг, лабораторийн шинжилгээнүүд болон шинжилгээний зургуудыг өргөдөл нь агуулна.

7.7 *Сэргээшийн эсрэг байгууллагын* ЭЗЗОХ-ны шаардсанаар нэмэлт шинжилгээ, үзлэг эсхүл шинжилгээний зураг авахуулах бол өргөдөл гаргагч, эсхүл тухайн өргөдөл гаргагчийг харьяалах улсын спортын байгууллага зардлыг хариуцна.



7.8 Өргөдөл нь зохих журмын дагуу эрх авсан эмчийн зүгээс *Тамирчны* эмчилгээнд *хориглосон бодис*, эсхүл *хориглосон арга барил* хэрэглэх болсон шаардлага, яагаад тухайн нөхцөлд өөр арга, зөвшөөрөгдсөн эмчилгээ хэрэглэж болохгүй байгаа, эсхүл болохгүй байсан тухайг батласан тайлбарыг агуулсан байна.

7.9 Хэрэглэхийг *хориглосон бодис*, эсхүл *хориглосон арга барилыг* ашиглах хугацаа, дараалал, давтамж болон хэмжээг нарийвчлан тодорхойлно.

7.10 *Сэргээшийн эсрэг байгууллага* холбогдох бүх бичиг баримтыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор ЭЗЗ олгох эсэх тухай шийдвэрийг гаргаж, тухайн шийдвэрийг *Тамирчинд* бичгээр хүргүүлнэ. *Сэргээшийн эсрэг байгууллагын шинжилгээний бүртгэгдсэн төхөөрөмж* тамирчинд ЭЗЗ олгож болохоор заасан бол *Тамирчин* болон ДСЭА-т зөвшөөрлийн хугацаа болон ЭЗЗ-тэй холбоотой бүх нөхцөл байдлын талаархи мэдээллийг агуулсан зөвшөөрлийг нэн даруй мэдэгдэнэ.


7.11 (a) Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4-т заасны дагуу Тамирчнаас гаргасан хянуулах тухай хүсэлтийг ДСЭА-гийн ЭЗЗОХ хүлээн авч Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4-т заасны дагуу *Сэргээшийн эсрэг байгууллагын* ЭЗЗ-ийн талаар гаргасан шийдвэрийг өөрчлөх эрхтэй. *Тамирчин* нь ДСЭА-гийн ЭЗЗОХ-нд *Сэргээшийн эсрэг байгууллагад* ЭЗЗ-ийн хүсэлтээ анхлан гаргахдаа өгсөн бүх мэдээллийг өргөдлийн хураамжийн хамтаар гаргаж өгнө. Хянан шалгах ажиллагаа дуустал анхны шийдвэр хүчин төгөлдөр хэвээр байна. Уг ажиллагаа нь ДСЭА мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор явагдана;

(b) ДСЭА хэдийд ч хянан шалгах ажиллагаа явуулж болно. ДСЭА-ийн ЭЗЗОХ-өөрийн хянан шалгах ажиллагааг 30 хоногийн дотор дуусгана.

7.12 ЭЗЗ олгосон шийдвэрийг хянаж үзээд өөрчилсөн бол, уг өөрчилсөн шийдвэрийг буцааж хэрэглэхгүй бас ЭЗЗ үйлчилж байх үед *Тамирчны* гаргасан амжилтыг хүчингүй болгохгүй. Уг өөрчилсөн шийдвэр нь *Тамирчинд* шийдвэрийг мэдэгдсэн өдрөөс хойш 14-ээс дээшгүй хоногийн дотор хүчин төгөлдөр болно.

8.0 ЭЗЗ хүссэн өргөдлийг хялбаршуулсан байдлаар өгөх журам (ХЖ)

8.1 *Хориглосон бодисын жагсаалтанд* орсон зарим бодисыг эрүүл мэндийн нөхцөл байдлыг харгалзан эмчлэх үүднээс хэрэглэх шаардлага Тамирчдын дунд элбэг тохиолддог нь батлагдсан. Эдгээр тохиолдолд 4 болон 7 дахь хэсэгт нарийвчлан заасан бүрэн өргөдөл шаардлагагүй. Энэ тохиолдолд ЭЗЗ-ийг хүсэх хялбаршуулсан ажиллагаа явагдана.



8.2 Хялбаршуулсан журамд зөвшөөрч болох *хориглосон бодис*, эсхүл *хориглосон арга барил* нь зөвхөн дор дурдсанаар хязгаарлагдана:

Ингальяци, түүнчлэн системчлээгүй глюкокортикостероид хэлбэртэй бета-2 агонист (формотерол, сальбутамол, сальметерол болон тербуталин).

8.3 Дээрх бодисуудаас аль нэгийг хэрэглэхийн тулд *Тамирчин Сэргээшийн эсрэг байгууллагад* эмчилгээний шаардлагыг нотолсон эрүүл мэндийн дүгнэлтийг гаргаж өгнө. II хавсралтад тусгасан, эрүүл мэндийн ийм дүгнэлт нь өвчний онош, хэрэглэх эм, хэмжээ, хэрэглэх дараалал болон эмчилгээний хугацааг тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд өвчний онош тогтоохын тулд авсан аливаа шинжилгээг мөн хамруулна (жинхэнэ үр дүн эсхүл нарийвчлалыг хамруулахгүй).

8.4 Хялбаршуулсан журам нь:

(a) Хялбаршуулсан журамд хамаарах *Хориглосон бодисуудыг* хэрэглэх зөвшөөрөл нь *Сэргээшийн эсрэг байгууллагаас* ирүүлсэн бүрэн гүйцэд мэдэгдлийг хүлээн авсан үеэс эхлэн үйлчилнэ. Бүрэн бус мэдэгдлүүдийг өргөдөл гаргагчид буцаана;

(b) бүрэн гүйцэд мэдэгдлийг хүлээн авсан тухайгаа *Сэргээшийн эсрэг байгууллага Тамирчинд* нэн даруй мэдээлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд сэргээшийн эсрэг олон улсын холбоо, үндэсний холбоо, үндэсний байгууллагад мэдэгдэнэ. *Сэргээшийн эсрэг байгууллага* нь зөвхөн *Олон улсын түвшний тамирчнаас* гаргасан мэдэгдлийг хүлээн авч ДСЭА-д хүргүүлнэ;


(c) ЭЭО-ийн мэдэгдлийг зөвхөн дор дурьдсанаас бусад тохиолдолд нөхөн олгохгүй:

- хойшлуулшгүй эмчилгээ, эсхүл хүнд өвчнийг эмчлэх зайлшгүй шаардлагатай байсан;

- онцгой нөхцөл байдлын улмаас *Сэргээшийн хяналтаас* өмнө өргөдөл гаргагчдад мэдүүлэх, эсхүл ЭЗЗОХ-нд хэлэлцэх хангалттай хугацаа, эсхүл бололцоо байгаагүй.

8.5 (a) ЭЗЗОХ-ны, эсхүл ДСЭА-гийн ЭЗЗОХ нь хялбаршуулсан журмаар гаргасан шийдвэрээ хэдийд ч хянан үзэж болно;

(b) ЭЗЗ хүсэх тухай өргөдлийг дараалан татгалзсаныг *Тамирчин* хянуулахаар хүсэлт гаргавал, ДСЭА-гийн ЭЗЗОХ *Тамирчны* зардлаар



шаардлагатай тохиолдолд түүнээс эрүүл мэндийн талаар нэмэлт мэдээллийг шаардан авах эрхтэй байна.

8.6 Эмчилгээний зориулалтаар олгосон зөвшөөрлийг ЭЗЗОХ-оос, эсхүл ДСЭА-гийн ЭЗЗОХ-оос хэдийд ч цуцалж болно. Энэ тухайг *Тамирчин, түүнийг харьяалах олон улсын холбоо болон Сэргээшийн эсрэг* холбогдох бүх байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

8.7 Ийнхүү цуцалсан нь *Тамирчинд* уг шийдвэрийг мэдэгдсэн даруй шууд хүчин төгөлдөр болно. Гэхдээ *Тамирчин* нь 7 дахь хэсэгт заасны дагуу ЭЗЗ авах хүсэлтийг гаргах эрхтэй байна.

9.0 Мэдээллийн төв

9.1 *Сэргээшийн эсрэг байгууллагууд* нь ДСЭА-г 7 дахь хэсэгт заасны дагуу олгосон бүх ЭЗЗ болон түүнд холбогдох бичиг баримтуудаар хангах үүрэгтэй.

9.2 Эмчилгээний зориулалтаар хялбаршуулсан журмын дагуу олгосон зөвшөөрлийн хувьд *Сэргээшийн эсрэг байгууллагууд* нь ДСЭА-г 8 дахь хэсгийн 4-т заасны дагуу *Олон улсын түвшний Тамирчнаас* гаргасан эрүүл мэндийн мэдээллээр хангана.

9.3 Мэдээллийн төв нь эрүүл мэндийн бүх мэдээллийн чанд нууцыг баталгааг гаргана.

УИХ-ын архив  
 Бүртгэлийн № 123  
**ХУУЛБАР ҮНЭН**  
 2017 оны 06 р сарын 09  
 Гарын үсэг *[Signature]*

*[Faint stamp and handwritten notes]*  
 7 6 11